



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2024 оны 08 сарын 22 өдөр

Дугаар Б/27

Модот

Э.Одончимэгийг ажилд томилох
тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 41, 47, 48 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол, 128 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт, 2018 оны 382 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрдэнэ-Очирын Одончимэгийг 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн багшаар томилсугай.

2. Багш Э.Одончимэгийг ТҮБД - 4 зэрэглэлийн 1,471,000 /Нэг сая дөрвөн зуун далан нэгэн мянга/-н төгрөгөөр цалинуулахыг нягтлан бодогч Д.Ганчимэгт зөвшөөрсүгэй.

3. Багш Э.Одончимэгт холбогдох эд хөрөнгийг хүлээлгэн өгч бүртгэл хөтлөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Э.Сугармаа – Арга зүйч

Нарийн бичиг: Д.Пүрэвсүрэн – Нярав

Гишүүн: Г.Энхчимэг – Багшийн туслах /Өмч хамгаалах зөвлөлийн дарга/

4. Хуульд заасан эрх үүргээ биелүүлж, холбогдох дүрэм журмыг чанд мөрдөн батлагдсан ажлын цагт бүлгийн хүүхдийн амь нас, эрүүл мэндийг бүрэн хариуцаж, цаг баримталж, хариуцлага санаачлалатай ажиллахыг багш Э.Одончимэгт үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧ



П.ГАНТУЯА